

Ц.Бавуудоржийн яруу найраг дахь өнгөний нэрээр илрэх
танин мэдэхүйн зүйрлэл

Шоовдорын ГАНТУЛГА*

Монгол Улс, Улаанбаатар хот, Монгол Улсын Боловсролын Их Сургууль,
Нийгэм хүмүүнлэгийн ухааны сургууль, Монгол хэлний тэнхим

Received: 20 October 2025 / Accepted: 24 October 2025 / Published: 30 December 2025

Хураангуй: Энэхүү өгүүлэлд яруу найрагч Ц.Бавуудоржийн уран бүтээл дэх өнгөний илэрхийлэл, түүний танин мэдэхүйн зүйрлэлийн онцлогийг судлав. Өнгөний илэрхийлэл хүний дотоод ертөнц, ориихуйн философи, соёлын ухамсарт хэрхэн нэвтэрч буйг танин мэдэхүйн зүйрлэлийн онолын хүрээнд тодруулахад уг судалгааны зорилго ориино. Судалгаанд нийт 14 өнгөний нэр, 229 удаагийн давтамжийг түүвэрлэн үндсэн хэрэглэгдэхүүн болгов.

Судалгааны үр дүнгээс харахад өнгө нь яруу найргийн гоо зүйн үүргээс давж, хүний сэтгэл, ориихуй, соёлын ухамсрын гүн утгыг илтгэж байна. Цагаан өнгө нь ариун, гэгээн чанар, насжилт ба үгүйрлийг; хөх өнгө нь тэнгэрлэг уужим ориихуйг; шаргал өнгө нь дурсамж ба тайван байдлыг; алаг өнгө нь эсрэг тэсрэгийн зохирлыг илэрхийлжээ. Ийнхүү Ц.Бавуудоржийн уран бүтээлд өнгө нь зөвхөн дүрслэлийн хэрэгсэл бус, хүн ба байгаль, орон зай ба цаг хугацааны уялдааг илтгэсэн танин мэдэхүйн зүйрлэлийн тогтолцоо бөгөөд монгол хүний соёл, сэтгэлгээний өвөрмөц хэв шинжийг тусгасан байна.

Түлхүүр үгс: Ц.Бавуудорж, уран сайхны эх, өнгө, танин мэдэхүйн хэл шинжлэл, зүйрлэл

Cognitive Metaphors Expressed through Color Names
in the Poems of Bavuudorj Ts.

GANTULGA Shoovdor

Department of Mongolian Language, School of Social Sciences and Humanities,
Mongolian National University of Education, Ulaanbaatar, Mongolia

Abstract: This article explores the use of color imagery and its cognitive-metaphorical characteristics in the poetry of the Mongolian poet Ts. Bavuudorj. The purpose of the study is to examine how color expressions penetrate the human inner world, existential philosophy, and cultural consciousness within the framework of cognitive metaphor theory. Observation, sampling, semantic, and stylistic analysis methods were applied, and a total of fifteen color terms with 229 occurrences were identified. The findings reveal that color expressions go beyond aesthetic ornamentation and

* © Ш. Гантулга, 2025, Email: shoovdorganaa@gmail.com



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license.

embody profound meanings related to emotion, existence, and cultural awareness. The color white represents purity, spirituality, aging, and transience; blue symbolizes celestial vastness and tranquility; golden evokes nostalgia and serenity; and variegated (multicolored) signifies the harmony of opposites. Thus, in Bavuudorj's poetry, color functions not merely as a visual element but as a cognitive-metaphorical system that expresses the interrelation between human beings and nature, space and time, reflecting the unique worldview and cultural cognition of the Mongolian people.

Key words: *Bavuudorj, Ts., Artistic Text, Color Symbolism, Cognitive Linguistics, Conceptual Metaphor*

1. Удиртгал

Танин мэдэхүйн хэл шинжлэлийн ухаан 1970-аад оны үед хөгжиж эхэлсэн бөгөөд салбар хоорондын харилцан үйлчлэлийн үр дүнд үүсэж, шинжлэх ухаануудын уулзвар дээр үнэлгээ дүгнэлт өгөх боломжийг нээсэн томоохон салбар юм. Өөрөөр хэлбэл, хэл, соёл, үзэл хандлага, сэтгэлгээний цар хүрээ, уран сайхны хэл найруулга, ертөнцийг танин мэдэх зэрэг нь судалгааны үнэлэлт, дүгнэлт хийх боломж бүхий нийгмийн хөгжил, түүх, хэл соёлын судлагдахуун болж байдаг.

Орчин үеийн хэлний судлалын гол асуудал нь утгын судлал гэж үзвэл, утга хүний сэтгэхүйд оршигч зүйл хэмээн судлаачид тодорхойлсоор байна. Танин мэдэхүйн хэл шинжлэлд хүний ертөнцийг үзэх үзлийг тодорхойлохын тулд туршлагыг үндэс болгодог ажээ.

Танихуйн ойлголт нь хүний өдөр тутмын амьдралтай шууд холбоотой бөгөөд танихуйн үйл ажиллагааг голлон баримталдаг. Танихуй нь хүн олж авсан мэдээллээ ашиглан удаа дараагийн дадлагаар туршлага, чадвар хуримтлуулан эзэмших үйл явц юм. Иймээс ч хүний туршлага, зан үйл, орчинтой салшгүй холбоотой. Хүн янз янзын орчинд оршин байдаг. Тухайлбал, амьтны зүйл, соёлын бүрэлдүүлбэр, нийгмийн нэг гишүүн тул хувь хүнийхээ хувьд амьдралынхаа оюун санааны болон биеийн хөдөлгөөний асар их туршлагыг хуримтлуулдаг. Танихуйн хэл шинжлэл нь эдгээр туршилагад үндэслэн, үгийн утгын шийжмийг нээн олж болно хэмээн тайлбарладаг. (Нансалмаа, Долгор 2014:168)

Дэлхийн өөр өөр газар нутагт аж төрөн амьдран сууж байгаа хүмүүсийн үзэл бодол, оюун сэтгэлгээ, авьяас билиг нь туршлагаас хамааран ёс заншил, шашин шүтлэг хийгээд соёлын ялгааг бий болгожээ. Үүнийг хэл шинжлэлийн үүднээс судлахдаа, танин мэдэхүй, хэл, соёлын гуравласан холбоонд авч үзэх шаардлагатай.

Ийнхүү гуравласан холбоонд тулгуурлан судлах нь хүний ертөнцийг таних, мэдрэх, үнэлэх, дүрслэх үйл явц хэлэнд хэрхэн шингэж буйг тайлбарлах чухал арга болдог. Хэл бол дан ганц харилцааны хэрэгсэл бус, хүний сэтгэхүйн бүтэц, соёлын ухамсар, дотоод ертөнцийн тусгал юм. Иймээс танин мэдэхүйн хэл шинжлэл нь хэлний үзэгдлийг логик, мэдрэмж, туршлага, сэтгэл хөдлөлийн огтлолцолд авч үздэг цогц судлал болжээ.

Танин мэдэхүйн зүйрлэл (conceptual metaphor) нь хүний ертөнцийг танин мэдэх онцлогийг илэрхийлэх чухал хэлбэр юм. Ж.Лакофф, М.Жонсон нарын “*Metaphors We Live By*” (1980) бүтээлд “метафор бол хэлний гоёл бус, харин сэтгэлгээний үндсэн загвар” хэмээн тодорхойлсон байдаг. Өөрөөр хэлбэл, хүн өөрийн туршлагын хүрээнд ойлгож буй зүйлээ танин мэдэхүйн шинжээр нь нэгэн төрлийн тогтолцоо болгож тархиндаа бүтээдэг. Энэхүү тогтолцоо нь хэлний түвшинд зүйрлэл хэлбэрээр илэрч, түүгээр дамжин тухайн ард түмний соёл, сэтгэлгээ, ертөнцийг үзэх үзэл илэрч байдаг.

Монголын уран зохиол, ялангуяа яруу найраг нь байгаль, хүн, оршихуйн харилцааг өнгө, дүрслэл, бэлгэдлээр илэрхийлдэг уламжлалтай. Өнгө бол зөвхөн нүдний мэдрэхүйгээр бус, сэтгэл зүйн, ёс суртахууны, философийн шинжтэй утгын өвөрмөц тогтолцоо юм. Иймд өнгөний хэрэглээ нь тухайн соёлын танин мэдэхүйн онцлог, дотоод сэтгэлгээний хэв шинжийг илтгэдэг.

Яруу найрагч Ц.Бавуудоржийн шүлгүүдэд өнгөний хэрэглээ нь уран сайхны дүрслэлийн түвшнийг давж, сэтгэл-ухамсар-байгалийн харилцан нэгдлийг илэрхийлсэн танин мэдэхүйн зүйрлэл болон хувирдаг. Түүний бүтээлд өнгө бол зөвхөн дүрслэлийн хэрэгсэл бус, сэтгэл зүйн оршихуй, дотоод ертөнцийн илэрхийлэл, мөнх оршихуйн философийн бэлгэдэл юм.

Энэхүү өгүүлэлд Ц.Бавуудоржийн яруу найраг дахь өнгөний илэрхийлэл хүний туршлага, сэтгэлгээ, байгаль-хүн-ертөнцийн холбоог хэрхэн илтгэж буйг танин мэдэхүйн зүйрлэлийн онолын үүднээс шинжилснээ өгүүлэхийг зорилоо.

Хүний ертөнцийг танин мэдэх үйл явц нь хэл, сэтгэлгээ, соёлын огтлолцолд оршдог бөгөөд тэдгээрийн нэгдэл нь тухайн ард түмний оюун санааны өвөрмөц шинж, уран сайхны сэтгэлгээний илэрхийлэл болдог. Танин мэдэхүйн хэл шинжлэл нь энэхүү нэгдлийг судалж, хүний сэтгэхүй хэрхэн хэлний бүтцээр илэрдэг, хэлний хэрэглээ хэрхэн соёлын ухамсарт нөлөөлдгийг тодруулахад чиглэдэг шинжлэх ухааны салбар юм.

Ж.Лакофф, М.Жонсон нарын “Metaphors We Live By” (1980) бүтээлд хүний сэтгэхүй танин мэдэхүйн зүйрлэлийн сүлжээгээр бүтдэг бөгөөд хүн ертөнцийг ойлгохын тулд зүйрлэлийн тогтолцоог ашигладаг гэж үзсэн байдаг. Үүгээр хэлний зүйрлэл (метафор) нь зөвхөн гоо зүйн гоёл бус, хүний ертөнцийг ойлгох арга болохыг нотолсон юм. Иймээс яруу найраг дахь зүйрлэл, ялангуяа өнгөний зүйрлэл нь тухайн ард түмний танин мэдэхүйн хэв шинж, соёлын ухамсрын нэгэн илэрхийлэл болдог гэж үзэж болно. Монголын уламжлалт сэтгэлгээ, уран зохиолд өнгө нь зөвхөн дүрслэлийн хэрэглүүр бус оршихуйн бэлгэдэл, ёс суртахууны үнэлэмж, сэтгэл зүйн төлөв байдлын илэрхийлэл болж ирсэн. Жишээлбэл, цагаан өнгө ариун байдал, гэгээн сэтгэлийг; хар өнгө зовлон, гунигийг; хөх өнгө тэнгэр, итгэл, мөнхийн оршихуйг; шар өнгө дэлхий, намар, амгалан байдлыг; алаг өнгө эсрэг тэсрэгийн зохирол, амьдралын хоёрдмол чанарыг илтгэнэ.

XXI зууны монгол яруу найргийн гол төлөөлөгч Ц.Бавуудорж нь эдгээр уламжлалт өнгөний бэлгэдлийг орчин үеийн танин мэдэхүйн уран сэтгэлгээтэй нэгтгэн, өнгөний дүрслэлээр дамжуулан хүн, байгаль, орчлонгийн уялдаа холбоог илэрхийлдэг. Түүний уран бүтээлд өнгө бол сэтгэл хөдлөлийн орон зай, ухамсрын дүрслэл, философийн илэрхийлэл болж, хэл-сэтгэлгээ-соёлын гуравласан уялдаа бодитоор илэрдгийг жишээгээр задлан тайлбарлах болно.

2. Судалгааны арга зүй

Энэхүү судалгаанд танин мэдэхүйн хэл шинжлэл, утга зүйн задлал, уран сайхны шинжилгээний аргуудыг уялдуулан ашиглахдаа ажиглалтын арга, түүвэрлэлт ба тоон шинжилгээ, утга зүйн ба танин мэдэхүйн шинжилгээ, уран сайхны эх задлал харьцуулсан шинжилгээний аргуудыг хэрэглэв. Ц.Бавуудоржийн 192 шүлэг, монгол хэлний товч тайлбар толь болон бусад тайлбар толь бичгүүд, цахим орчны эх бичвэр зэргийг хэрэглэгдэхүүн болгов.

3. Судалгааны хэсэг

Ц.Бавуудоржийн яруу найргийн бүтээлээс өнгөний нэрсийг түүвэрлэн ажиглахад 14 өнгөний нэр 229 удаагийн давтамжтайгаар илэрч байна. Үүнд ан амьтан, байгалийн үзэмж, хүний сэтгэл, бүтээл туурвил, нүүдэлчин монголчуудын соёл, зан үйлийг дараах байдлаар дүрслэн илэрхийлсэн байна.

1. “Цагаан” – *цагаан заан, цагаан уул, цагаан гантиг, цагаан бадам цэцэг, уулын цагаан, цагаан оргил, цагаан яс, цагаан дун, цав цагаан толгой, цагаан сүү, цагаан өмсгөл, цагаан өвсхөн, цагаан цастын орон, хэсэг цагаан манан, цагаан, цагаан салхи, цагаан тоорцог, цагаан өмсгөлтэй дагинас, суу билгийн цагаан бороо, хээрийн цагаан бороо, цагаан сарны томьёо, цагаан хяруу, цагаан чулуун сарнай, цагаан гэрэл, нарийн цагаан хур, огторгуйн цагаан заадаас, уулын цагаан шөнө, намрын цагаан хус, мөндрийн цагаан зурвас, амар болоочийг тээсэн цагаан*

тэмээ, цагаан цүү шиг садан минь, цагаан гардийн нүд, цагаан тарнийн гэрэл, цагаан зүг, цагаан дуутай шувуу, намрын сэмбэрүү цагаан исгэрээ, тарнийн цагаан цэцэг, цагаан зандан сэтгэл, цагаан залаат жигүүртэн

2. “Хар” – хар уул, хар гээг, хар архи, хар, цагаан хоёр тэнд уруул нийлүүлж байдаг, хар илд, хар сүлд

3. “Хөх” – хөх далай, хөх салхи, хөх диваажин, хөх амуу, хөх толгод

4. “Шар” (шаргал) – шар өвс, шаргал диваажин, шаргал амьсгал, шаргал тоос, шаргал дөл, шаргал гуниг, зүүрмэг шаргал орчлон, шар нар

5. “Алтан” – алтан ширээ, алтан утас, алтан хэвлий, алтан бийр, алтан сүм

6. “Тунгалаг” – тунгалаг бясалгал, тув тунгалаг эгишиг, тунгалаг харц, тунгалаг мэдрэмж, тунгалаг хүн, алаггүй тунгалаг тэнгэрс залбирч байна, тунгалаг энгэртээ тэвэрнэ үү, тунгалаг андын дэргэд, гэнэхэн тунгалаг харц, үхэл ирэхэд би тув тунгалаг болно, үр минь, хүү минь харин тод тунгалаг төрнө, хоёр тунгалгийн хоорондохыг хорвоо гэдэг юм даа, хоёр тунгалгаас бусдад нь хонгор минь битгий итгээрэй, өнөд тунгалаг наран дор, тунгалаг цагаан үүлс, урсгал тунгалаг гол, миний тунгалаг сар, хосгүй тунгалаг нүдтэн, тунгалагхан тэр шилтгээнүүд, нэгнээ хайрлахдаа л хүмүүн гэгч тунгалаг болдог, айсуу цагийг үүрдийн тунгалагт урвуулах, биширмээр зөөлөн, тунгалаг бай гэж шивнэсэн, сарны тунгалагт би гунигламааргүй байна, тунгалаг үүрийн гэгээ, хөмсгөн дороос тасрах аниргүй тунгалаг хорвоо, халхын хөх тэнгэр мэт тунгалаг биеийг тэвэрсэнгүй, тунгалаг гоо бүсгүй өмнүүр гунхаж одно

7. “Цэнхэр” – эгэл цэнхэр, цэнхэр хязгаар, цэнхэр асар, цэнхэр тэнгэр, цэнхэрхэн далай

8. “Улаан” – улаан нар, улаан хошуутан, улаан зандан унь, улаан орхимж, улаан навчис, улаан уруул, улаан дөл, улаан лаа, хацар ийм улаан, амьдын улаан бөмбөрцөг, улаан өмсгөлтэй дагинас, улаан гэрэлт луу, улаан дээлтэй өвгөн

9. “Ногоон” – ногоон хүж, ногоон арц, ногоон өмсгөл, ногоог зөрөг, ногоон замаг

10. “Бор” – бор газар, бор бие, бор цус, бор хэдэн дусал, бор өргөө

11. “Ягаан” – ягаан дэлбээ, ягаан зам, ягаан мутар, ягаан дөл

12. “Хүрэн” – хүрэнтэн найгах тал, хүрэн жигүүртэн, хүрэнтэн бэлчих

13. “Буурал” – буурал уулс, буурал сансар, буурал лус, буурал эх, буурал хөгжимч, буурал хүннү, буурал үлгэр, буурал дорно, буурал хүмүүн

14. “Алаг” – алаг нүд, алаг хорвоо гэж илэрхийлэн өөрийн дотоод мэдрэмжийн эерэг болон сөрөг үнэлэмжийг илэрхийлжээ. Эдгээр илэрхийллээс зөвхөн танин мэдэхүйн зүйрлэлийн утга илэрхийлсэн зарим жишээ буюу 14 өнгөнөөс цагаан, хөх, шар (шаргал) өнгөөр илэрсэн жишээг судалгааныхаа хүрээнд нийцүүлэн ашиглах болно.

3.1. Цагаан өнгө

Цагаан өнгийг утга, өнгөөр бэлгэдэх сэтгэлгээтэй холбон авч үзэхэд хамгийн олон удаагийн давтамжтай, найруулгын чимэг тодотгол илэрч байна. Монголчуудын цагаан өнгийн бэлгэдлийг эрдэмтэн С.Дулам “Цагаан өнгө нь нарны гэрэл, гэгээн цагаан өдрийн дохио төлөөлөл болж дүрслэгдээд эртний хүмүүсийн байгалийн шүтлэг, үзэл бодролоос аяндаа үүсэж болохыг, тэр нь хүн зоноос үл нууцлах, ил тодорхой, цэвэр ариун, сайн сайхан үйлс хэргийн ёгтлол болж, дохио утга нь гүнзгийрэн даамжирч болохыг харж болно” (Дулам, 2007: 17) гэсэн нь монгол хүний байгалийн үзэгдэл, юмсыг таньж мэдсэн мэдлэг, туршлагадаа үндэслэн сэтгэж буй сэтгэлгээний өвөрмөц онцлог, мөн цагаан өнгийг монгол хэлтэй ард түмнүүд ёслол хүндэтгэлийн утгатай эх өнгө гэж үздэгтэй холбоотой. Бид судалгааныхаа зорилгын дагуу цагаан, цайвар өнгийн сэтгэлгээнд үндэслэн

Дэлт хүлгийн толгой овоон дээр цайрахад уйлдаг
Дэлхийн санчигт цагаан сор унахад уйлдаг
Би дорно (“Дорно” шүлгээс).

Өнгийн сэтгэлгээ (Color cognition)-ний талаас авч үзвэл “цайрах”, “цагаан сор” гэдэг нь шууд утгаараа өнгөний илэрхийлэл бөгөөд монгол сэтгэлгээнд цагаан өнгө – *хиргүй тунгалаг байдал, ариун чанар гэсэн* утгаас гадна нас барах, хөгширөх, гуних гэх мэт эсрэг утгыг илэрхийлдэг. Тухайлбал, монголчуудын дунд өргөн дэлгэр хэлэлцдэг “Ертөнцийн гурван цагаан” хэмээх хэвшмэл хэллэгийн:

Өсөхөд шүд цагаан

Өтлөхөд үс цагаан

Үхэхэд яс цагаан гэсэн хэллэгтэй дүйх монгол үндэсний энэхүү уламжлалт сэтгэлгээг Ц.Бавуудоржийн шүлгээс мөн харж болохоор байна. “Цайрах”, “цагаан сор” нь хуучрах, үгүйрэх, мөхөх, цаг хугацааны урсгал зэрэг санаа илэрхийлж байна. “Цагаан сор” гэдэг нь хүний үс бууралт, *настай хүний санчиг цайх* нь хөгширөх, доройтохыг тодруулдаг илэрхийлэл юм. “Санчиг” гэх үгийг “Монгол хэлний товч тайлбар толь”-д: “эмэгтэйчүүдийн үсний гөрөөнд ороогүй үлдээсэн сул буюу богино үс” (Цэвэл, 1966: 409) гэж тайлбарлажээ. Ц.Бавуудоржийн дээрх шүлгээс дэлхий ертөнцийн зөөлөн, чимээгүйхэн хөгширч буйг урнаар илэрхийлж **зүйрлэсэн** амьд сүнслэг сэтгэлгээний илэрхийллийг харж болно. Дэлхий бол “амьтай, хөгширдөг, эмзэг оршихуй” гэсэн үзэлд тулгуурласан хүний нас нэмэхэд хамгийн түрүүнд бууралтдаг хэсэгтэй зүйрлэжээ. Ер нь монгол сэтгэлгээнд дэлхий, байгаль, уул зэргийг амьтай, сэтгэлтэй, хөгширдөг гэж үзэх бэлгэдэл түгээмэл бий. “Цайрах” гэх өнгөний илэрхийлэл нь эмзэглэх, мэлмэрэх гуниглах, уярах утгатай мэдрэхүйн шинжийг хослуулан туурвидаг.

Танин мэдэхүйн зүйрлэлийн онолын үүднээс задалбал, дараах зүйрлэлийн хэлбэрүүд гарч байна.

а) ЦАГ ХУГАЦАА БОЛ ХӨГШРӨЛ, МӨХӨЛ

“Цайрах” өнгөний цайралт биш, харин хөгширөх үйл явцтай зүйрлэж байна.

“Дэлхийн санчигт цагаан сор унах” гэдэг нь хүн хувьсахын адил дэлхий хөгширч байна гэсэн зүйрлэл. Энэ бол ХҮН = ДЭЛХИЙ гэсэн гүн бүтэцтэй танин мэдэхүйн зүйрлэл юм.

б) БИЕ МАХБОД БОЛ ГАЗАР НУТАГ, ОРОН ЗАЙ

“Дэлхийн санчигт” гэхээр дэлхийг хүний биетэй зүйрлэжээ. Овоон дээр цайрах гэдэг нь нэгэн цагт тэнхээтэй байсан хүлэг цагааран бууралтахыг илэрхийлж, мөнх бусын дүрслэл болж байна.

в) УЙЛАХ БОЛ УЯРАХ, МЭДРЭХ. Энэ бол энгийн гуниг биш, гүн ухааны, түүхийн, оршихуйн гуниг, нөгөө талаар уянга юм.

г) “Би дорно” – хураангуй, гүн бэлгэдэл: шүлэгч өөрийгөө: “Дорно” буюу дорнын хүн, дорнын сэтгэлгээний *гоо зүйн, оюуны, уянгын* түвшинд нэгтгэж байна. Энэ нь БИ = ДОРНО БОЛ МЭДРЭМТГИЙ, ТУНГАЛАГ, УЯРАМТГАЙ ОРШИХУЙ гэсэн танин мэдэхүйн зүйрлэл юм. Шүлэгт субъектив би = дэлхий ертөнц = дорнын ухаан хэмээх гурвал илэрхийллийг бүтээж, өнгө, орон зай, цаг хугацаа, бие махбод зэрэг танин мэдэхүйн хүрээ дамнасан гүн ухааны уран дүрслэл болон хувирчээ.

Нэрт эрдэмтэн Я.Цэвэл цагаан өнгийг ариун цагаан ажил, арван цагаан буян, хиргүй цагаан сэтгэл, цагаан явдал, цагаан үйл, цагаан хүн гэх мэтээр хүн нийгмийн амьдралын доторх үнэн зөв, ариун шударга, сайн сайхны мөн чанар тэмдэг болгодог тухай өгүүлсэн. Үүнээс гадна, цагаан үсэг, цагаан бичиг, цагаан толгой, цагаан газар, цагаан зам гэх мэтээр үйл ажил, юмны амар хялбар бартаа төвөггүйг илэрхийлдэг талаар онцлон дурдсан (1959: 3) дурдсан байна. Энэ бүхэн нь монголчууд маш эрт цагаас эхлэн цагаан өнгийг эрхэм нандин өнгө гэж үзсээр ирсний гэрч юм. Зарим түүх сударт эртний монголчууд цагаан өнгийг эрхэмд үзэж аливаа баяр ёслол, шинэлэх цагаалах зэрэг сайн сайхныг эрхэмлэх үйлсэд цагаан хувцас өмсдөг тухай дурдсан байна. Эдгээр эрдэмтдийн онол, таамаглал болон зохиолчийн уран сайхны эх дэх “цагаан” хэмээх өнгө заасан үгийн сонголт дээр тулгуурлан дүгнэвэл, монголчууд цагаан

өнгийг эрхэмлэдэг нь буддын шашны ариун, гэгээн бэлгэдэлтэй уялдаж, сэтгэл зүй, ёс суртахууны үнэт зүйлсийн чухал хэсэг болно. Цагаан өнгө нь монголчуудын хувьд зөвхөн гоо зүйн утга илэрхийлэгч бус, байгаль, ёс суртахуун, нийгмийн үнэт зүйлсийг багтаасан олон талт бэлгэдэл бөгөөд цагаан өнгийг эрхэмлэх уламжлал нь соёлын өв, оюун санааны үнэ цэнийг хадгалж ирсэн өвөрмөц чанар юм. Тиймээс цагаан өнгө нь монголчуудын амьдралын үнэт зүйлс, ёс зүйн үзэл баримтлал, соёлын илэрхийлэл болж чадсан эх өнгө, эрхэм чанарын илэрхийлэл гэдгийг Ц.Бавуудоржийн яруу найргаар дүгнэж болно.

3.2. Хөх өнгө

XIV зууны үеийн монгол хэлний дурсгал “Мукаддимат-ал-Адаб” хэмээх толь бичигт (көкэ) гэсэн үгийг “Хөхөөс хур буув” гэсэн өгүүлбэрээр жишээ болгосныг үзвэл “хөх” гэдэг үг бол “тэнгэр” гэх үг юм. Эртний монголчууд тэнгэрийг “хөх” гэдэг байж “хөх хүрхрэх” гэдэг бол “тэнгэр дуугарах”, харин “хөхөөс хур буух” гэдэг нь тэнгэрээс бороо орохыг хэлж байна. (Өнөрбаян нар, 2021: 21). Түүнчлэн “Тэнгэр гэдэг үгээс “тэнгис буюу” “усан дээр буусан тэнгэрийн дүрс” хэмээх үг үүссэн тухай мөн дурдсан байна.

Монголчуудын оюун санаан дахь хамгийн итгэлт өнгө бол хөх өнгө юм (Батсайхан, 2017: 139). Хөх өнгөнд хамгийн их итгэл найдвараа өгч, хөх толбоор үндэстнийхээ баталгааг хийж, мөнх хөх тэнгэртээ сүслэн залбирч, төрийнхөө сүлд, далбаанд мөнхөлсөн байдаг нь үүний баталгаа юм.

Ц.Бавуудоржийн бүтээлүүдэд: *“хөх диваажин, хөв хөх тарни, хөх тэнгэр, хөх ариц, хөх амуу, хөх толгод, хөх судар, хөх энгэр”* гэсэн үгс амар амгалан, итгэл найдвар, сүсэг бишрэл, амралт, эрх чөлөөг илэрхийлэх утгатай байна.

Дээр хөх тэнгэрт

Нэгэн хувилгаан бий

Дүрс хувирсан гэгээн биеэ хүмүүн

Тайлж тоглох нь түүнд таалагддаг... гэж “хөх тэнгэрт” хэмээн өнгөөр орон зайн утга илэрхийлжээ. Монгол хэлэнд хөх өнгө нь зөвхөн өнгө биш, үндэсний сэтгэлгээний өвөрмөц ойлголт, “тэнгэр” шүтлэгийн төв ухагдахуун цаг хугацаа, орон зайг илтгэх давхар үүрэгтэй байдгийг үүгээр баримтжуулж болно.

“Хөв хөх тарниа

Үржүүлсээр л үлдсэн дээ”

Энэ хэсгийн “Хөв хөх” нь монгол хэлэнд цагаан-цэнхэртэх, цэлмэг, уужим гэх шинжийг өнгөөр илэрхийлэх ба ихэнхдээ тэнгэрийн өнгө, хийсвэр чанар, урт наст бэлгэ тэмдэг, ариун чанартай холбогддог. “Хөв хөх тарни” гэдэг нь өнгөний бэлгэдлээр тэнгэрлэг, ариун, эртний, ид шидийн тарнийг хэлж буй хэрэг. Хэл шинжлэлд “тарни” гэх үг нь утга санааны хувьд дуудлага, хэллэг төдий бус, шүтлэг, сүсэг бишрэлийн хүч бүхий үг. “Самгарди хэлээр урьж унших их бага хэмжээний аливаа хүслийг бүтээхэд зориулсан номын нэр” (МХИТТ., mongoltoli.mn) “Үржүүлсээр үлдэх”-танин мэдэхүйн хувьд өвлүүлэх, дамжуулах, уламжлуулах гэсэн ойлголт юм. Энд өнгөний сэтгэлгээ нь тэнгэрлэг чанар болон монгол тарнийн хүч чадалтай холбогдож, өнгөөр дамжуулан сэтгэлгээний гүн илэрхийлэл болжээ.

3.3. Шар (шаргал) өнгө

Ц.Бавуудоржийн бүтээлд буй нэгэн өвөрмөц танин мэдэхүйн зүйрлэл бол “шаргал” тодотголт жишээнүүд юм.

Хүснэгт 1. Ц.Бавуудоржийн яруу найргийн “шаргал” тодотголт өгүүлэмжүүд

№	Мөр	Танин мэдэхүйн утга
1	“Энэ миний л гэрэлт агшин...” “Энүүхэнд найгах шаргал диваажин...”	“Шаргал диваажин” = газар дээрх амгалан, намар шиг намуухан дээд оршихуй
2	“Хул шаргал өвснөө Хувирч одсон бүсгүйчүүд бий”	Хуучин дурлал, улирсан, байгальд ууссан сэтгэлийн хойноос явсан оршихуйн дүр
3	“Уруул дээр минь унасан Алтан шаргал шүлэгхэн минь”	Шүлэг бол дурсамж. Шаргал шүлэг бол намрын өнгөтэй дурсамж, уруулаар дамжин гарч буй дотоод мэдрэмж
4	“Тэндээс бурхдын шаргал амьсгал сонсогддог”	Шаргал амьсгал бол нам гүмийн орчлонгийн шивнээ. Шаргал нь энд бурхадтай холбогдож буй гэгээрэл, хүч юм.
5	“Дорно зүгт өвс болно би” Долгилон шаргалтсаар л байна	Байгальтай нэгдэнэ, буцалтгүй нэгдэх, бодит орчлонд шингэх
6	“Зүүрмэг шаргал орчлон цээжинд илхэн байлаа”	“Зүүрмэг” – нойрон дундах, хөвөлзсөн байдал. “Шаргал орчлон” – дотоод ертөнц, тайван, бүдэг гэрэлт орчлон. Энэ нь сэтгэлд ууссан, бүдэг гэрэлт дурсамж мэт оршиж байна.
7	“Хөнгөн шаргал үүлс чиний нутгийнх байлаа”	“Хөнгөн үүлс” – дурсамж мэт зөөлөн, түргэн, агаарт замхрах зүйл. “Шаргал” үүлс = өөр нэгэн ертөнцийн гоо сайхан, харин “чиний нутгийнх” гэдгээр энэ дурсамж эсвэл хүн аль хэдийн тэнгэрийн орон руу одсон байж болох мэдрэмжийг агуулна.
8	“Зүүдний шаргал хөндийд зөвхөн чи л байлаа”	“Зүүдний хөндий” бол бодит бус, дотоод ухамсар. “Шаргал хөндий” бол намар шиг өнгөтэй дурсамжийн орон зай. “Зөвхөн чи л байлаа” гэдгийн шаргал өнгө нь тэр хүний сэтгэлийн орон зайг бүхэлд нь төлөөлж байна.

Шар, шаргал өнгө нь Ц.Бавуудоржийн танин мэдэхүйн зүйрлэлд хүний дотоод орчлон, дурсамж, нам гүм мэдрэмжийн өнгө болжээ. Хэл зүйн хувьд өнгө нэрлэсэн үг боловч, хүний сэтгэлийн онцгой байдал, үгүй болсон зүйлс, зүүдний бодит мэт дүрслэл болон өргөжсөн нь танин мэдэхүйн утга өнгөнд суурилсан бэлгэдэлт зүйрлэлийн сонгодог жишээ болж буй юм. “Монгол ёс, заншлын их тайлбар толь”-д “шар” өнгийн нэр нь “шороо” (siroi), “шир” (sir - будаг) гэсэн үгтэй нэгэн гаралтай гэж дурдсан байдаг бөгөөд ертөнцийн үүслийн домогт тэргүүн туурвигч нэгэн атга шороог шившин тарнидаж газар тарьсан гэдэг өгүүлэмжтэй утга авцалдах ба угтаа шорооны өнгийг нэрлэн заасан буюу шорооноос гаргасан будагч бодис “шир” хэмээхийг хүртээл нэр болгосон, энэ нь цаашид шар шороон тивийг өнгө зүсээр нь хүндэтгэн “алтан дэлхий” хэмээн нэрлэж, Ази дахины домог зүйд байдаг тэр төсөөлөлд хүргэсэн хэрэг (Дулам, 2007: 3) гэсэн тайлбарыг энд онцлох нь зүйтэй.

3.4. Буурал өнгө (зүс)

Ц.Бавуудоржийн бүтээлд буурал тодотголтой есөн илэрхийлэл байгаа бөгөөд “буурал уулс, буурал сансар, буурал лус, буурал эх, буурал хөгжимч, буурал хүннү, буурал үлгэр, буурал дорно, буурал хүмүүн” хэмээн настай, ухаантай, хүндтэй, өнө эртний, цаг хугацааны уртад нугарсан гэх утга, байгалийн мөнх, дөлгөөн чанарыг заажээ. Тухайлбал, буурал хөгжимчин гэхэд урт удаан оршихуй, урлагийн мөнхийн амин сүнс гэж зүйрлэсэн, чингэж сонсож мэдэрсэн танин мэдэхүйн утга илэрч байна. “Буурал” гэдэг үг цаг хугацааг илэрхийлж, байгалийг хүншүүлж, хүн, орчлон, байгаль, урлагийг сэтгэхүйн болоод утгын хүрээнд нэгтгэсэн утгын төв нь юм. Ц.Бавуудоржийн “Ловончимбын дууль”-д буй:

“Говийн зөөлөн шар нар

Нүд далдичин дагажээ

Хавийн хөх толгод

Бут сөөгөндөө хяржээ

Таанын цагаан толгой

Ташуурдуулсан мэт хийсжээ” гэсэн хэсэгт Ж.Лакоф, М.Жонсон нарын танин мэдэхүйн зүйрлэлийн онолд үндэслэн өнгөний талаас танин мэдэхүйн зүйрлэлийн шинжилгээ хийхэд “шар” өнгө нь монгол соёлд намар, амгалан, тайван, төгсгөлийн гэрлийг илэрхийлдэг ба “Зөөлөн” гэх тодотголоор амьдралын гэгээн, уужим, уянгын мэдрэмжийг илэрхийлж байна. Энэ жишээгээр НАРНЫ ГЭРЭЛ БОЛ АМГАЛАН СЭТГЭЛ, ШАР ӨНГӨ БОЛ ТӨГСГӨЛ гэсэн зүйрлэл үүсэж байна.

“Нүд далдичин дагажээ” – “Нүд далдичин дагах” гэж нарны хөдөлгөөнийг хүншүүлэн, амьд биет мэт дүрсэлжээ. Танин мэдэхүйн хувьд байгаль нь хүн рүү, хүн нь мэдрэмж рүү шилжих сэтгэлгээг илэрхийлж байгаа бөгөөд БАЙГАЛЬ БОЛ АМЬТАЙ, МЭДРЭМТГИЙ ОРШИХУЙ гэсэн зүйрлэл үүсэж байна.

“Хавийн хөх толгод бут сөөгөндөө хяржээ” – “Хөх толгод” нь тэнгэртэй нийлсэн уужим орон зай, холын гуниг, намуун мэдрэмжийг илэрхийлж байна. “Хяржээ” гэх үйл үг нь цаг хугацааны шилжилт буюу нар жаргах мөчийг бэлгэдсэн байна. Танин мэдэхүйн зүйрлэлээр ЦАГ ХУГАЦАА БОЛ ГЭРЛИЙН ӨӨРЧЛӨЛТ, ХӨХ ТОЛГОД БОЛ БАЙГАЛИЙН ОРШИН СУУГЧ гэсэн зохиогчийн ертөнцийг таньсан туршлагыг харж болохоор байна.

“Таанын цагаан толгой ташуурдуулсан мэт хийсжээ” – “Тааны цагаан толгой” нь байгаль дахь амьд биетийг насжилт, уналт, үүл адил хөдөлгөөнтэй хэмээн дүрсэлж байна. “Ташуурдуулсан мэт хийсжээ” гэдэг нь хүчтэй салхинд найгах, цагаан өнгийн зүйл нисэх зүйрлэлээр амьдралын түр зуурын мөн чанарыг илэрхийлдэг. Танин мэдэхүйн зүйрлэлийн онолоор: ЦАГААН ӨНГӨ БОЛ ТӨГСГӨЛ, БАЙГАЛИЙН ХӨДӨЛГӨӨН БОЛ АМЬДРАЛЫН ХӨДЛӨЛ гэсэн зүйрлэл үүсжээ.

Ертөнцийн гурван цагаан”-ы хувилбарт “*Үгүйрэхэд хот цагаан*” гэсэн мөр байдаг нь цулгүй хоосны төлөөлөл бөгөөд ядуу зүдүү, ор юмгүй гэсэн утгыг гаргасан сөрөг үнэлэмж юм. Ийнхүү монгол хэлэнд цулгүй цагаан, цулгүй хоосон гэсэн нийлэмж үг байдаг нь монголчууд цагаан өнгийг оргүй хоосон, огт юмгүй гэсэн утгаар зүйрлэн хэлдгийн баримт тул дээрх хувилбарын санааг баталж байна гэж үзэж байна. Монголчуудын энэ сэтгэлгээтэй ойролцоо баримт франц хэлэнд бас байдаг, хоосорч үгүйрэх гэсэн утгыг “цагаан модтой үлдэх” гэсэн өвөрмөц хэллэгээр илэрхийлдэг нь сонирхолтойн дээр хоёр үндэстний сэтгэлгээний нийтлэг шинжийг харуулж байна. Монголын соёлд уламжлалт сэтгэлгээнд хар цагаан нь харилцан эсрэг олон зүйлийн бэлгэдэл, төлөөлөл болдгийн жишээ нь цагаан идээний эсрэг хар идээ гэсэн ойлголт бий. Цагаан идээ нь хүндэтгэлийн утгатай байхад хар нь (хар цай, хар шөл, хар архи гэх мэт) ядуурал, гуйланчлал, азгүй байдлыг илэрхийлдэг (Энхжаргал, 2012:103) гэж үзсэн нь сонирхолтой юм.

Энэхүү шүлэгт шар, хөх, цагаан гурван өнгө нь тус тусдаа танин мэдэхүйн зүйрлэл үүсгэж, байгаль ба хүний сэтгэл хөдлөлийг уялдуулан нэгтгэж байна.

Хүснэгт 2. Ц.Бавуудоржийн яруу найргийн шар, хөх, цагаан өнгийн утга, бэлгэдэл

Өнгө	Танин мэдэхүйн утга	Бэлгэдэл
Шар	Амгалан, дулаан, төгсгөлийн гэрэл	Намрын нар, амарлингуй оршихуй
Хөх	Тэнгэрлэг уужим, уянга, тайвшрал, түүхэн цаг хугацаа	Үдшийн гуниг, оршихуйн уужим
Цагаан	Ариун, үхэл, төгсгөл	Түр зуурын оршихуй, цэвэршилт

Дээрх шүлэгт өнгө нь байгаль – сэтгэл – цаг хугацааны уялдааг илтгэсэн танин мэдэхүйн гинжин зүйрлэлийг үүсгэжээ.

3.5. “Алаг” үзэл (өнгөний үзэл)

Монгол хэлэнд “Аяганы алгаас адууны алаг дээр” гэх мэт хэллэг арвин бий. Энэ зүйрлэлийн “аяганы алаг” гэдэг нь “хүнийг ялгаварлаж харилцах” гэсэн санааны ёгт нэрлэлт юм. “Аяга” нь аяга сав, аяга халбага гэх мэт эдлэл хэрэглэлийг нэрлэсэн шууд утгаараа биш, аяганы хэмжээ, доторх юмных нь чанар чансааг харилцахуйн болзмол тэмдэг – дохио болгож илэрхийлсэнд хэргийн гол учир оршиж байгаа билээ. “ ‘Аяганы алгаас адууны алаг дээр’ гэсэн энэ хэллэгийг ‘Аяганы алгаас адууны алаг’ дээр гэдэг хэллэгээс ‘аяга’, ‘аяг’ гэсэн үгсийн дуудлага ижилссэнээс үүссэн ‘буруу’ хувилбар гэж тэмдэглэсэн зүйл тааралддаг. Гэвч монгол хэлц үгийн санд ‘аяга’-аар алагчлах, ‘аяг’-аар алагчлах гэсэн хоёр зүйл хэллэг байдаг” (Баянсан, 2016:55) байна.

Өвөр дээрх

Шүлгийн дэвтрээс өөр бясалгалгүй

Гэрэл сүүдрийн

Алаг хорвоогоос өөр гэргүй

Гэрийн утаат

Аглаг монголоос өөр дэргүй

Хөөрхий, миний бараа...

Хүснэгт 3. Ц.Бавуудоржийн “Аяа” шүлгийн “алаг” хэмээх үгийн утгын задлал

№	Шүлгийн мөр	Танин мэдэхүйн зүйрлэл	Утга
1	“Өвөр дээрх шүлгийн дэвтрээс өөр бясалгалгүй”	УХААН БОЛ ШҮЛЭГ БИЧИХ ҮЙЛ, ӨВӨР БОЛ ОРШИХУЙН ТӨВ	Оюун санаа, бясалгал зөвхөн уран бүтээлээр илэрдэг. Шүлэг нь зөвхөн уран сайхны илэрхийлэл биш, амьдралын утга.
2	“Гэрэл сүүдрийн алаг хорвоогоос өөр гэргүй”	ОРЧЛОН БОЛ АЛАГ ГЭР ГЭРЭЛ, СҮҮДЭР БОЛ ХҮНИЙ АМЬДРАЛЫН ХОЁР ТАЛ	Яруу найрагч амьдралын ээдрээтэй, сайн муу холилдсон орчлонг л оршин байх орон зай гэж үзсэн.
3	“Гэрийн утаат аглаг монголоос өөр дэргүй”	МОНГОЛ НУТАГ БОЛ ОРШИХУЙН ТҮШИГ, АМРАХ ГАЗАР	Монголын утаатай гэр, хээр тал, аглаг байгаль бол яруу найрагчийн хувьд амьдралын гол түшиг тулгуур, амар амгалан оршихуйн цэг.

Дээрх “Гэрэл сүүдрийн алаг хорвоогоос өөр гэргүй” гэх танин мэдэхүйн зүйрлэлтэй утга адил “алаг” гэдэг нь солонгорсон, нэгдмэл биш, эсрэг тэсрэг өнгөний нийлэмж бөгөөд “гэрэл сүүдэр” гэдэг ч хоёр туйл болон, эсрэг тэсрэг оршихуйн сэтгэлгээ, “алаг хорвоо” буюу хүний

хорвоо бол зөвхөн өнгө төдий биш, харин хоёр туйлын тэмцэл, бас зохирол юм гэдгийг баталж байна. Ер нь өнгө гэгч нь аливаа юмны будаг, гэрлийн ялгавар болоод зогсохгүй цаг хугацаа, орон зайг заах тэр ч байтугай хүний зан аашийг ч илэрхийлэх боломжтой. “Алагчлах” гэвэл бусдыг гадна дотно болгон ялгаварлах гэсэн утгатай бөгөөд алаг эрээн хорвоо, “Алагчлан үзэх адгийн явдал”, “Шаазгай шиг алаг болсноос, хэрээ шиг хар болсон нь дээр” гэсэн хэвшмэл хэллэгүүд хүний зан араншингийн талаарх сөрөг үнэлэмжийг илэрхийлнэ.

4. Судалгааны үр дүн

1. Монгол уран сайхны эх дэх өнгөний нэрс нь зөвхөн уран сайхны дүрслэл биш, харин гүн ухааны бэлгэдэл, сэтгэл зүйн төлөв, байгаль, нийгмийн уялдаат утга агуулгыг илэрхийлдэг байна.
2. Цагаан, хөх, шар, алаг зэрэг өнгө бүр тус тусдаа танин мэдэхүйн онцлог, соёлын үнэт зүйл, сэтгэл зүйн гүн гүнзгий агуулгыг илэрхийлдэг ажээ.
3. Монголчуудын өнгөний бэлгэдлийн уламжлалт сэтгэлгээ нь орчин үеийн уран зохиолд хэрхэн өөрчлөгдөж, шинэ утга агуулгаар баяжиж байгааг бидний судалгаа харуулж байна.
4. Монгол уран сайхны эх дэх яруу найргийн зүйрлэлүүд нь хүн, байгаль, цаг хугацаа, сэтгэл зүйн холбоог хэлээр дамжуулан илэрхийлэх танин мэдэхүйн оновчтой хэлбэр болж байна.
5. Энэ судалгаа нь соёл, хэл шинжлэл, уран зохиолын уялдаа холбоог илрүүлж, өнгөний бэлгэдлийн талаарх судалгааг гүнзгийрүүлэх боломжийг илтгэж байна.

5. Дүгнэлт

Өнгийг танин мэдэхүйн зүйрлэлийн үүднээс авч үзвэл байгалийн үзэгдэл, оюун санаа, мөнхөд оршихын бэлгэ тэмдэг, амьдралын жам ёс зохиогчийн оюун санаанд буух танин мэдэхүйн илэрхийллээр эх хэлний баримт, хэлний дархлааг хадгалах үндэсний сэтгэлгээний онцлогийг илрүүлэн харах боломжтой байна. Өнгө илэрхийлсэн үгийн утгад суурилан зохиогчийн танин мэдэхүйн туршлагыг мөн таньж болно.

Ц.Бавуудоржийн яруу найраг дахь өнгөний илэрхийлэл нь монгол хүний сэтгэлгээ, соёлын ухамсар, оршихуйн гүн ухааны илэрхийлэл юм. Түүний бүтээлд цагаан өнгө нь ариун, гэгээн чанар, насжилт, мөхлийн бэлгэдэл; хөх өнгө нь тэнгэрлэг уужим оршихуй, итгэл, амар амгалангийн илэрхийлэл; шаргал өнгө нь дурсамж, намрын дулаан мэдрэмж; алаг өнгө нь орчлонгийн эсрэг тэсрэгийн зохирлыг тус тус илтгэнэ. Танин мэдэхүйн зүйрлэлийн онолоор авч үзвэл, эдгээр өнгө нь “ХҮН БОЛ ДЭЛХИЙ”, “ЦАГ ХУГАЦАА БОЛ ӨӨРЧЛӨЛТ”, “БАЙГАЛЬ БОЛ АМЬТАЙ ОРШИХУЙ” зэрэг суурь танин мэдэхүйн загваруудын илэрхийлэл болж байна. Ийм учраас Ц.Бавуудоржийн уран бүтээл бол зөвхөн уянгын яруу найраг бус, сэтгэл зүй – гүн ухаан – соёлын нэгдэл бүхий танин мэдэхүйн зүйрлэлийн цогц бүтээл болохыг харуулж байна.

Ном зүй

А. Монгол хэлээр:

1. Батсайхан, Ц. (2017). *Монгол соёлын өнгөний бэлгэдэл судлал*. Улаанбаатар: Битпресс. [Batsaikhan, Ts. *Mongol soyolyn öngönii belgedel sudlal* [Batsaikhan, Ts. [The Symbolism of Colors in Mongolian Culture]. Ulaanbaatar: Bitpress. 2017.]
2. Баянсан, Ж. (2016). *Соёл, хэл, үндэсний сэтгэлгээ*. Улаанбаатар: МУИС хэвлэл. [Bayansan, J. *Soyol, khel, ündesnii setgelgee*. [Culture, Language, and National Mentality]. Ulaanbaatar: National University of Mongolia Press. 2016]
3. Дулам, С. (2007). *Монгол бэлгэдэл зүй II*. Улаанбаатар: Соёмбо Принтинг. [Dulam, S. *Mongol belgedel züi II*] [Mongolian Symbolism II]. Ulaanbaatar: Soyombo Printing. 2007]

4. Нансалмаа, Н., Долгор, С. (2014). *Танин мэдэхүйн хэл шинжлэл*. Улаанбаатар: Соёмбо притинг. [Nansalmaа, N., Dolgor, S., *Tanin medekhüin khel shinjlel* [Cognitive Linguistics]. Ulaanbaatar: Soyombo Priting. 2014.]
5. Өнөрбаян, Ц., Соронзон, Д. (2021). *Монгол үгийн гарал судлалын үндэс*. Улаанбаатар: МУИС хэвлэл. [Onörbayan, Ts., Soronzon, D. *Mongol ügiin garal sudlалyn үндэс*. [Foundations of Etymology in the Mongolian Language] Ulaanbaatar: NUM Press. 2021.]
6. Цэвэл, Я. (1966). *Монгол хэлний товч тайлбар толь*. Улаанбаатар: ШУА хэвлэл. [Tsevel, Ya. *Mongol khelnii товч tailbar toli* [A Concise Explanatory Dictionary of the Mongolian Language]. Ulaanbaatar: Academy of Sciences Press. 1966.]
7. Цэвэл, Я. (1959). *Монголчуудын эрхэмлэдэг өнгө*. Улаанбаатар: Шинжлэх ухаан, дээд боловсролын хүрээлэнгийн газар. [Ya. Tsevel. *Mongolchuudiin erkhemledeg öngö*. [Colors Valued by Mongolians] Ulaanbaatar: Institute of Science and Higher Education. 1959.]
8. Энхжаргал, С. (2012). *Монгол хэлний тогтвортой нэгжийг танин мэдэхүйн хэл шинжлэлийн талаас судалсан нь*. Улаанбаатар: МУБИС хэвлэл. [Enkhjargal, S. *Mongol khelnii togtvortoi negjiig tanin medekhüin khel shinjleliin talaas sudalsan ni*. [A Cognitive Linguistic Study of Stable Units in the Mongolian Language]. Ulaanbaatar: MNUES Press. 2012.]

Б. Англи хэлээр:

9. Лакофф, Ж., & Жонсон, М. (1980). *Metaphors We Live By*. Chicago: University of Chicago Press. [G. Lakoff, M. Johnson. (1980). *Metaphors We Live By*. Chicago: University of Chicago Press.]